



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэн АгроЭкологи бизнесийн сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны үнээ нөхсөн нийт 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 (хоёр) ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуулийн хэлтсийн дарга Л.Цэдэвсүрэн, Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэн АгроЭкологи бизнесийн сургуулийн захирал Л.Пүрвээ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020
оны 7 дугаар сарын 20-ны өдрийн
77 дугаар тогтоолын хавсралт

ХААНС-ийн харьяа Ургамал газар тариалан хурээлэн Агроэкологи бизнесийн сургуулийн undsэн хөрөнгөй бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаах тээврийн хэрэгслийн жагсаалт

Д/Д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хурумтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх ёртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Төвөгт Харрер 3806 ДАХ, арал MCU100033981	1999/2011	309875	14,500,000.00	14,500,000.00	-	-	1,000,000.00
2	Хүндай Верна 7929 ДАР арал31774	1999/2008	250000	5,500,000.00	5,500,000.00	-	-	300,000.00
					20,000,000.00 (хорин сая)			1,300,000.00 (нэг сая гурван зуун мянга)
					НИЙТ ХӨРӨНГИЙН ДУН			